



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 01 өдөр

Дугаар А/277

Хэрлэн сум

С.Жавхлангийн сургалтын төлбөрт
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 3 дугаар сарын 31-ний “Мэргэжилтэй ажилтан бэлтгэх, хүний нөөцийг бүрдүүлэх журам батлах тухай” 24 дүгээр тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 3 дугаар сарын 09-ний “Аймгийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” арваннаймдугаар хуралдааны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Зөгийн үүр” арга хэмжээний хүрээнд “Мэргэжилтэй ажилтан бэлтгэх, хүний нөөцийг бүрдүүлэх журам”-ын хэрэгжилтийг хангах зорилгоор номын санч С.Жавхлангийн сургалтын төлбөрт зориулж 1,000,000 (нэг сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх “Шаардлагатай мэргэжлээр суралцаж буй оюутнуудад дэмжлэг үзүүлнэ” зардлаас олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ